



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 5 сарын 10 өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

Г Журамд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 147 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам /цаашид “журам” гэх/-д дараах өөрчлөлтийг оруулсугай.

1/ Журмын 3.2, 5.2, 5.3 дахь хэсгийн “Валют арилжааны ББСБ” гэснийг “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.6, 7.1.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд” гэж;

2/ Журмын 3.3, 4.3, 5.2, 5.3 дахь хэсгийн “Зээл санхүүжилтийн ББСБ” гэснийг “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.1-7.1.7, 7.1.9, 7.1.10-д заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд” гэж;

3/ Журмын 3.4, 4.4, 5.2, 5.3 дахь хэсгийн “Хөрөнгө удирдлагын ББСБ” гэснийг “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.1-7.1.11-д заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Журмын “16-а” дугаар хавсралтын “Валют арилжааны ББСБ” гэснийг “журмын 3.2-т заасан этгээд” гэж, “16-б” дүгээр хавсралтын “Зээл санхүүжилтийн ББСБ” гэснийг “журмын 3.3-т заасан этгээд” гэж, “16-в” дүгээр хавсралтын “Хөрөнгө удирдлагын ББСБ” гэснийг “журмын 3.4-т заасан этгээд” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Журамд холбогдох өөрчлөлтийг оруулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

00:90